

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/30/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас:70543156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас:70543179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй.....	20
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил арилгах 2 албан шаардлага өглөө.....	20
4.4 Зөвлөмж өгөгдөөгүй.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГСА	Говьсүмбэр аймаг
ГХУСАХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: govjsumber@audit.gov.mn

2022.02.25 № 14

танай _____-ны № _____-т

**"АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ"-ЫН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Ж.ОЮУНБИЛЭГ ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020066

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,077,021.00	22,831,217.97
33	АВЛАГА	2,262,874.00	210,070.97
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	210,070.97
33500	Бусад авлага	2,262,874.00	0
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,262,874.00	0
34	УРЬДЧИЛГАА	0	1,880,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	0	1,880,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	0	0
35	БАРАА МАТЕРИАЛ	21,814,147.00	20,741,147.00
35400	Хангамжийн материал	21,814,147.00	20,741,147.00
35410	Бичиг хэргийн материал	980,000.00	935,500.00
35420	Аж ахуйн материал	14,967,849.00	17,238,349.00
35430	Сэлбэг хэрэгсэл	605,000.00	605,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,962,298.00	1,962,298.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	172,911,107.58	461,216,335.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	172,911,107.58	461,216,335.62
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	122,081,107.58	410,386,335.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,300,000.00	325,183,376.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-374,206.59	-410,714.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,000,000.00	87,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0	-29,000,000.04
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	39,269,095.96	40,383,095.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,671,035.20	-19,672,365.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,268,849.76	24,557,849.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,711,596.35	-17,654,906.03
39300	Биет бус хөрөнгө	50,830,000.00	50,830,000.00
39301	Програм хангамж	1,120,000.00	1,120,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,120,000.00	-1,120,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	50,830,000.00	50,830,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	196,988,128.58	484,047,553.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	210,070.97
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	210,070.97
41300	Өглөг	0	210,070.97
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	50,070.97
41360	Бусад өглөг	0	160,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	160,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	196,988,128.58	483,837,482.62
51	Засгийн газрын хувь оролцоо	196,988,128.58	483,837,482.62
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	120,685,525.69	120,685,525.69
51200	Хуримтлагдсан үр дүн	60,051,233.77	346,900,587.81
51210	Өмнөх үеийн үр дүн	-46,192,805.19	57,788,359.77
51220	Тайлант үеийн үр дүн	106,244,038.96	289,112,228.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,251,369.12	16,251,369.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	196,988,128.58	484,047,553.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	458,556,100.00	809,724,926.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,000,000.00	322,883,376.00
120	Нийтлэг татварын бус орлого	87,000,000.00	322,883,376.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	87,000,000.00	322,883,376.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	371,556,100.00	486,841,550.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,000,000.00	42,544,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.00	42,544,750.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	331,556,100.00	444,296,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	331,556,100.00	444,296,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	352,312,061.04	519,662,698.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,312,061.04	519,662,698.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	225,555,431.83	420,200,211.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,688,735.62	118,242,813.27
210101	Үндсэн цалин	98,688,735.62	118,242,813.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,455,465.63	15,282,031.78
210201	Тэтгэврийн даатгал	8,507,916.53	10,552,319.19
210202	Тэтгэмжийн даатгал	986,889.37	1,182,428.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	789,511.21	945,942.52
210204	Ажилгүйдлийн даатгал	197,376.13	236,485.63
210205	Эрүүл мэндийн даатгал	1,973,772.39	2,364,856.31
2104	Хангамж, бараа материалын зардал	12,623,419.10	20,985,405.60
210401	Бичиг хэрэг	1,664,800.00	1,977,800.00
210402	Тээвэр, шатахуун	8,701,000.00	15,299,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,257,619.10	3,708,605.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,195,310.00	7,112,487.50
210604	Урсгал засвар	5,195,310.00	7,112,487.50
2107	Томилолт, зочны зардал	4,840,000.00	5,751,000.00
210702	Дотоод албан томилолт	4,840,000.00	5,751,000.00

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,187,040.44	5,449,257.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,990,540.44	2,970,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	2,309,100.00	2,296,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,400.00	109,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	0	50,832.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,565,461.04	247,377,216.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,424,600.00	198,942,349.35
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,940,000.00	7,603,719.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,200,861.04	40,831,148.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,756,629.21	99,462,486.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	49,394,201.00	17,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	49,394,201.00	17,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,919,038.00	46,782,513.32
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,673,638.00	44,982,513.32
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,245,400.00	1,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,443,390.21	35,679,973.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,443,390.21	35,679,973.18
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	106,244,038.96	290,062,227.92
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	949,999.88
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	949,999.88
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	106,244,038.96	289,112,228.04

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,685,525.69	2,946,524.40	-46,192,805.19	77,439,244.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	120,685,525.69	2,946,524.40	-46,192,805.19	77,439,244.90
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	13,304,844.72	0	13,304,844.72
9	Тайлант үеийн үр дүн	0	0	106,244,038.96	106,244,038.96
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,685,525.69	16,251,369.12	60,051,233.77	196,988,128.58
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	120,685,525.69	16,251,369.12	60,051,233.77	196,988,128.58
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-2,262,874.00	-2,262,874.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	120,685,525.69	16,251,369.12	57,788,359.77	194,725,254.58
19	Тайлант үеийн үр дүн	0	0	289,112,228.04	289,112,228.04
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	120,685,525.69	16,251,369.12	346,900,587.81	483,837,482.62

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	371,556,100.00	486,841,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	371,556,100.00	486,841,550.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,000,000.00	42,544,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.00	42,544,750.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	331,556,100.00	444,296,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	331,556,100.00	444,296,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	360,966,100.00	479,638,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	360,966,100.00	479,638,550.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	234,209,471.73	380,176,063.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,688,735.62	118,242,813.27
210101	Үндсэн цалин	85,767,581.99	76,960,798.75
210102	Нэмэгдэл	11,031,153.63	35,647,014.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,890,000.00	5,635,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,455,466.57	15,282,031.78
210201	Тэтгэврийн даатгал	8,507,917.47	10,552,319.19
210202	Тэтгэмжийн даатгал	986,889.37	1,182,428.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	789,511.21	945,942.52
210204	Ажилгүйдлийн даатгал	197,376.13	236,485.63
210205	Эрүүл мэндийн даатгал	1,973,772.39	2,364,856.31
2104	Хангамж, бараа материалын зардал	16,190,919.10	17,641,905.60
210401	Бичиг хэрэг	1,933,300.00	1,933,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.00	12,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,257,619.10	3,708,605.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,905,000.00	7,382,487.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	605,000.00	270,000.00
210604	Урсгал засвар	6,300,000.00	7,112,487.50
2107	Томилолт, зочны зардал	4,840,000.00	8,751,000.00
210702	Дотоод албан томилолт	4,840,000.00	5,751,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	3,000,000.00

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,236,750.44	5,449,257.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,040,250.44	2,970,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	2,309,100.00	2,296,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,400.00	109,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	0
210807	Газрын төлбөр	0	50,832.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,892,600.00	207,426,568.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,902,600.00	199,822,849.35
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,990,000.00	7,603,719.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,756,628.27	99,462,486.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	49,394,201.00	17,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	49,394,201.00	17,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,919,037.06	46,782,513.32
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,673,637.06	44,982,513.32
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,245,400.00	1,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,443,390.21	35,679,973.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,443,390.21	35,679,973.18
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,590,000.00	7,203,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,590,000.00	7,203,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,590,000.00	7,203,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,590,000.00	7,203,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,590,000.00	7,203,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,590,000.00	-7,203,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /				
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	444,296,800.00	408,616,826.82	35,679,973.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	444,296,800.00	408,616,826.82	35,679,973.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	420,296,800.00	384,834,313.50	35,462,486.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,216,000.00	118,242,813.27	27,973,186.73
210101	Үндсэн цалин	103,173,000.00	76,960,798.75	26,212,201.25
210102	Нэмэгдэл	34,727,000.00	35,647,014.52	-920,014.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,316,000.00	5,635,000.00	2,681,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,944,900.00	15,282,031.78	2,662,868.22
210201	Тэтгэврийн даатгал	12,202,600.00	10,552,319.19	1,650,280.81
210202	Тэтгэмжийн даатгал	1,435,600.00	1,182,428.13	253,171.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,148,400.00	945,942.52	202,457.48
210204	Ажилгүйдлийн даатгал	287,100.00	236,485.63	50,614.37
210205	Эрүүл мэндийн даатгал	2,871,200.00	2,364,856.31	506,343.69
2104	Хангамж, бараа материалын зардал	18,056,600.00	17,641,905.60	414,694.40
210401	Бичиг хэрэг	1,933,300.00	1,933,300.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.00	12,000,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,123,300.00	3,708,605.60	414,694.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,800,000.00	9,671,487.50	128,512.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	270,000.00	270,000.00	0.00
210602	Тавилга	2,300,000.00	2,289,000.00	11,000.00
210604	Урсгал засвар	7,230,000.00	7,112,487.50	117,512.50
2107	Томилолт, зочны зардал	8,787,100.00	8,751,000.00	36,100.00
210702	Дотоод албан томилолт	5,787,100.00	5,751,000.00	36,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,000,000.00	3,000,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,236,300.00	5,449,257.00	2,787,043.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,570,500.00	2,970,500.00	2,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,341,300.00	2,296,525.00	44,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	247,500.00	109,400.00	138,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	0.00
210807	Газрын төлбөр	55,000.00	50,832.00	4,168.00

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	211,255,900.00	209,795,818.35	1,460,081.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	205,255,900.00	204,432,099.35	823,800.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	5,363,719.00	636,281.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,000,000.00	23,782,513.32	217,486.68
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	17,000,000.00	17,000,000.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	17,000,000.00	17,000,000.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0	0	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,000,000.00	6,782,513.32	217,486.68
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	4,982,513.32	17,486.68
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,800,000.00	200,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	444,296,800.00	408,616,826.82	35,679,973.18
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	444,296,800.00	408,616,826.82	35,679,973.18
320001	Орон нутгийн төсвөөс	444,296,800.00	408,616,826.82	35,679,973.18

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
21	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,000,000.00	42,544,750.00
210	УРСГАЛ ЗАРДАЛ	40,000,000.00	42,544,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,544,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		304,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,240,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,000,000.00	40,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,000,000.00	40,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,000,000.00	40,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,000,000.00	42,544,750.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,000,000.00	42,544,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон санхүүжилт	40,000,000.00	42,544,750.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд тус аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 28 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллага нь Нутгийн удирдлагын нэгдмэл байдлыг хангаж, иргэдийн хүсэл сонирхол, эрх ашгийг дээдэлж, тэдний идэвхтэй оролцоонд тулгуурлан орон нутгийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг оновчтой шийдвэрлэх эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн бодлого, чиг хандлагыг оновчтой тодорхойлох, аймгийнхаа эдийн засаг, нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэх.
2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалтыг бүх талаар хөгжүүлж, түүний ил тод нээлттэй байдлыг хангах
3. Хурлын хяналтын тогтолцоог улам боловсронгуй болгож түүний үр нөлөөг дээшлүүлэх
4. ИТХ-ын төлөөлөгч нь тойргийнхоо ард иргэдтэй байнгын харилцан ажиллагаатай байж, тэдний эрх ашгийг төлөөлөн илэрхийлдэг зарчмыг хэрэгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудитор нь тайлант онд тус газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн зардлын 357,693.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,576.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 3,861.5 мянган төгрөгөөр тогтоосон

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 287,059.4 мянган төгрөгөөр буюу 145.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			0.0
Авлага	2,262.9	210.1	-2,052.8
Урьдчилгаа		1,880.0	1,880.0
Бараа материал	21,814.1	20,741.1	-1,073.0
Үндсэн хөрөнгө	172,911.1	461,216.3	288,305.2
Нийт хөрөнгө	196,988.1	484,047.6	287,059.4
Өр төлбөр	0.0	210.1	210.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	196,988.1	483,837.5	286,849.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	196,988.1	484,047.6	287,059.4

Авлага дансны үлдэгдэл 210.1 мянган төгрөг болж 2,052.8 мянган төгрөгөөр буурсан нь шүүхийн шийдвэрээр авлага хүчингүй болсноос буурч, ажилчдын цалингаас суутгах

НДШ-ийн авлагыг зөрүүтэй суутгасан, ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж урамшууллаас ХХОАТ суутган тооцоогүй зэргээс авлага нэмэгдсэн байна.

Авлагын үлдэгдэл нь НДШ-ийн авлага 50.7 мянга, ХХОАТ-ын авлага 160.0 мянган төгрөг тус тус байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 1,880.0 мянган төгрөг нь ажил үйлчилгээ үзүүлэх гэрээгээр олгосон ажил, үйлчилгээ нь тайланд ондоо багтаж хийгдээгүйгээс урьдчилж гарсан зардлаар бүртгэснээс үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 20,741.1 мянган төгрөг болж 1,073.0 мянган төгрөгөөр хасагдсан нь тайлант онд өмнөх оны үлдэгдэл шатахууныг зарцуулсан нь нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 21,814.1 мянган төгрөг байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 30,929.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 32,002.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 20,741.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 529,074.3 мянган төгрөг болж 326,286.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Чойрын хийдийн гол дуганы барилгыг үнэ төлбөргүй хүлээн авсан нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 202,787.9 мянган төгрөг байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 7,203.0 мянга, үнэ төлбөргүй АИТХТ-ийн 2021.11.29-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор Чойр хийдийн гол дуганы барилга 322,883.4 мянга, нийт 330,086.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, АИТХТ-ийн 2021.12.30-ны 56 дугаар тогтоолоор 3,800.0 мянган төгрөгийн нисдэг камерыг Боржигин өв музейд шилжүүлж, 529,074.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Тайлант онд биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Өглөгийн үлдэгдэл 210.7 мянган төгрөг нь ажилчдад өгөх өглөг 50.7 мянга, ХХОАТ-ын өглөг 160.0 мянган төгрөг тус тус байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 483,837.5 мянган төгрөг болж 286,849.4 мянган төгрөгөөр өссөн нь авлагыг данснаас хассан 2,262.8 мянган төгрөгөөр хасагдаж, тайлант хугацааны үр дүн 289,112.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 341,168.8 мянган төгрөгөөр буюу 72.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс санхүүжилтийн орлого 102,740.7 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 235,883.3 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 2,544.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж материаллаг өөрчлөлт гарсан.

Тайланд онд анх УИХ-аас батлагдсан төсөв, орон тоог нэмж баталсан, төсвийн тодотголоор ГХУСАХ-ний зардлыг 37,419.0 мянган төгрөгөөр нэмж баталсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга үнэ төлбөргүй хүлээн авсан зэрэг нь нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 161,969.5 мянган төгрөгөөр буюу 45.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс цалин болон НДШ-ийн зардал, ГХУСАХ-ний зардал, урсгал засварын зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал нь тус тус материаллаг өөрчлөлт гарсан байна.

Энэ нь тайлант онд орон тоонд шинээр ажилтан томилогдож ажилласан, автомашинд засвар үйлчилгээ хийсэн, үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авснаар үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал тус тус нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн данснаас хассан авлага 2,262.8 мянган төгрөгөөр нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 821,733.1 мянга, нийт зарлагыг 821,733.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 414,855.3 мянган төгрөгөөр бууруулж, 406,877.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Анх 406,877.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч төсвийн тодотголоор багаж, техник, хэрэгсэл зардлыг 3,230.0 мянган төгрөгөөр хасаж, урсгал засварын зардлыг 3,230.0 мянга, ГХУСАХ-ний зардлыг 37,419.0 мянга, нийт 40,649.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 444,296.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд 80801-үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 249,470.4 мянга, 80205-мэдээлэл сурталчилгааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 570.5 мянга, 80224-Зөвлөл, хороо комиссын гишүүдийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,000.0 мянга, 80305-бараа үйлчилгээний бусад зардлыг санхүүжүүлэхээр 5,000.0 мянга, 80802-ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,000.0 мянга, 80,818-хэлмэгсдийн ар гэрт олгох тэтгэмж урамшууллын арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,000.0 мянга, 81,505-ИТХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг арга хэмжээг санхүүжүүлэхээр 17,000.0 мянга, “70709- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийн хүрээнд 80201-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 155,255.9 мянга, 82310-гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,000.0 мянга нийт 444,296.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 444,296.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 444,296.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 408,616.8 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 35,680.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 408,616.8 мянган төгрөг буюу 92.0 хувьтай байгаа нь бүрэн орон тоогоор ажиллаагүйгээс цалин, НДШ-ийн зардлыг 30,635.9 мянга, хангамжийн бараа материалын зардлыг 414.7 эд хогшил худалдан авах зардлыг 128.5 мянга, дотоод албан томилолтын зардлыг 36.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 2,787.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,460.0 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 217.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилт 444,296.8 мянга, үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийн орлого 322,883.4 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 42,544.7 мянга, нийт 809,724.9 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт санхүүжилт 444,296.8 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 42,544.7 мянга, нийт 486,841.5 мянган төгрөгийн санхүүжилтийг тайлагнасан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос цагаатгалын санхүүжилт 40,000.0 мянга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас санхүүжилт 2,544.7 мянга, нийт 42,544.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, цагаатгалын нөхөн олговорт 40,000.0 мянга, сургалтын үйл ажиллагаанд 2,544.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзэж Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй, төсвийн тодотголоор багаж техник хэрэгслийн зардлыг 3.230.0 мянган төгрөгөөр хасаж урсгал засварын зардлыг нэмэгдүүлсэн, даргын ширээ, номын тавиур, сандал зэрэг эд хогшил худалдан авахад 2,289.0 мянга, 5 удаагийн сургалт зохион байгуулахад 6,466.2 мянга, 8 удаа тэмцээн уралдаан зохион байгуулахад 17,243.4 мянга, нийт 29,228.6 мянган төгрөгийг зарцуулсанд зөрчлийн давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

3.8 Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн “Иргэдийн Төлөөлөгчдийн хурал” нь 2021 онд нийт 361,006.0 мянган төгрөгийн 107 мэдээллийг байршуулахаас 156,087.5 мянган төгрөгийн 24 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

1. Хөрөнгө зарцуулах 18,447.7 мянган төгрөгийн 12 захирамж
2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 77,987.0 мянган төгрөгийн 4 зарлагын мөнгөн гүйлгээ
3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл тайлагнал 12,000.0 мянган 1 хөрөнгө оруулалтын ажил
4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7 ажлын 47,652.8 мянган төгрөгийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг тус тус мэдээлээгүйд зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгснийг хэрэгжүүлж ажилласан бөгөөд хэрэгжилт 100.0%-тай байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт /мянган.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2		2		-	-	-
Нийт дүн	2		2		-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал байхгүй байна

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 208,142.6 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 22,826.5 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 185,316.1 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 22,826.5 мянган төгрөгийн 6 алдааг залруулав. Үүнд:

1. Завсрын аудитаар 2021 оны эхний хагас жилд хөдөлгөөн гараагүй шалтгаанаар үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч залруулсан
2. Завсрын аудитаар 2021 оны эхний хагас жилд 4,404.0 мянган төгрөгийн бараа материалын тайланг гаргасан боловч тайланг баталгаажуулаагүй зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч залруулсан
3. Үндсэн хөрөнгө худалдан авсан 7,203.0 мянган төгрөгийн зардлыг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлаар тайлагнаагүй зөрчлийг аудитын явцад залруулсан
4. Худалдан авсан 9,179.5 мянган төгрөгийн бараа материалыг нярвын тайланд дутуу тусгасныг аудитын явцад залруулсан
5. Санхүүгийн тайланд Урьдчилж гарсан зардлыг 1,880.0 мянган төгрөгөөр дутуу тусгасныг аудитын явцад залруулсан
6. Ажиллагсад олгосон тэтгэмж, урамшууллын зардлаас 160.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй, татварын хэлтэст төлөх өглөгөөр тусгаагүй байсныг аудитын явцад залруулсан

4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил арилгах 2 албан шаардлага өглөө.

- 4.3.1. Шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө зарцуулах 18,447.7 мянган төгрөгийн 12 захирамж, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 77,987.0 мянган төгрөгийн зарлагын 4 мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл тайлагнал 12,000.0 мянган төгрөгийн 1 хөрөнгө оруулалтын ажил, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7 ажлын 47,652.8 мянган төгрөгийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг тус тус мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтуудыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

- 4.3.2. Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй, төсвийн тодотголоор багаж техник хэрэгслийн зардлыг 3,230.0 мянган төгрөгөөр хасаж урсгал засварын зардлыг нэмэгдүүлсэн, даргын ширээ, номын тавиур, сандал зэрэг эд хогшил худалдан авахад 2,289.0 мянга, 5 удаагийн сургалт зохион байгуулахад 6,466.2 мянга, 8 удаа тэмцээн уралдаан зохион байгуулахад 17,243.4 мянга, нийт 29,228.6 мянган төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1, 1.4, 1.5, 1.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	8	208,142.6	6	22,826.5	0	0	2	185,316.1	0	0